

СЭТГЭЦ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эмчилгээ, үйлчилгээний 2 шинэ арга, технологийг практикт нэгдүгээр зохиогчоор нэвтрүүлэн үр дүнд хүрсэн байх /эмчилгээ эрхэлсэн орлогч даргын тодорхойлолт хавсаргах/;
2. Эрдэм шинжилгээ, судалгааны 2-оос доошгүй бүтээл нэгдүгээр зохиогчоор анагаах ухааны хэвлэлд нийтлүүлсэн байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
3. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 3 зөвлөгөө зөвлөмж /10 нүүр буюу 5-аас доошгүй хуудастай/ нэгдүгээр зохиогчоор шинээр боловсруулж хэвлүүлсэн, олон нийтийн хүртээл болгосон байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
4. Мэргэшлийн дагуу дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эмчилгээ, үйлчилгээний 3 шинэ арга, технологийг практикт нэгдүгээр зохиогчоор нэвтрүүлэн үр дүнд хүрсэн байх /эмчилгээ эрхэлсэн орлогч даргын тодорхойлолт /;
2. Эрдэм шинжилгээ, судалгааны 3-оос доошгүй бүтээл нэгдүгээр зохиогчоор анагаах ухааны хэвлэлд нийтлүүлсэн байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
3. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 5 зөвлөгөө зөвлөмж /10 нүүр буюу 5-аас доошгүй хуудастай/ нэгдүгээр зохиогчоор шинээр боловсруулж хэвлүүлсэн, олон нийтийн хүртээл болгосон байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
4. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 1 гарын авлага /хэвлэлийн 5 хуудас буюу 80 нүүр ба 40-өөс доошгүй хуудастай /нэгдүгээр зохиогчоор шинээр боловсруулж хэвлүүлсэн, олон нийтийн хүртээл болгосон байх /бүтээлийн эх хувь ба хуулбарын хамт бүрдүүлэх/;
5. Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эмчилгээ, үйлчилгээний 5 шинэ арга, технологийг практикт нэгдүгээр зохиогчоор нэвтрүүлэн үр дүнд хүрсэн байх /эмчилгээ эрхэлсэн орлогч даргын тодорхойлолт хавсаргах/;
2. Мэргэшлийн чиглэлээр мэргэжил арга зүйн бодлогын баримт, бичиг 2 ба түүнээс дээш боловсруулан батлуулсан байх /стандартын дугаар тавигдсан байх, баталгаажсан эх хуулбар/;
3. Эрдэм шинжилгээ, судалгааны 5-оос доошгүй бүтээл нэгдүгээр зохиогчоор анагаах ухааны хэвлэлд нийтлүүлсэн байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
4. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 2 гарын авлага /хэвлэлийн 5 хуудас буюу 80 нүүр ба 40-өөс доошгүй хуудастай /нэгдүгээр зохиогчоор шинээр боловсруулж хэвлүүлсэн, олон нийтийн хүртээл болгосон байх /бүтээлийн эх хувь ба хуулбарын хамт бүрдүүлэх/;
5. Үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн байгууллагад ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад багшилсан байх, шинэ залуу эмч, мэргэжилтнүүдийг шавилан сургасан байх
6. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад багшилсан байх, шинэ залуу эмч, мэргэжилтнүүдийг шавилан сургасан байх;
7. Тухайн мэргэжлийн салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцон, бодлого арга зүйн асуудлыг дэвшүүлж шийдвэрлүүлэн, удирдан зохион байгуулсан байх /тухайн үйл ажиллагааг зохион байгуулсан, эсвэл идэвхтэй оролцсон болохыг батлах баримт нотолгоо, тухайлбал удирдан зохион байгуулсан сургалтын хөтөлбөрийн эх хувь гэх мэт/;
8. Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх